



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар

11295

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Гадаад байгууллагын төлөөлөгч, иргэнтэй харилцах журам” батлах тухай А/153 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай” 29 дугаар тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 07 дугаар тогтоол, 2025 оны “Чингэлтэй боловсрол-2028” арга хэмжээ батлах тухай 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Япон улсын Шизүока мужийн Яйзу хоттой хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг сайжруулах, гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлийн дагуу сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдах дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сонгон шалгаруулалтын тайланг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010851